



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/09

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.4, 9.3.10, 9.3.13, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XXIII хуралдааны 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хог хаягдлыг менежментийг сайжруулах, хог хаягдлын чиглэлээр хэрэгжих гадаад, дотоодын төсөл хөтөлбөрт хамрагдах болзол шаардлагад нийцсэн төсөл сонгох, бичүүлэх зөвлөх үйлчилгээ худалдан авах зардалд 19.000.000 (Арван есөн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 19.000.000 (Арван есөн сая) төгрөгийг Засаг дарга дансны "Засаг даргын үйл ажиллагааны болон мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардал"–аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар) -д даалгасугай.

ДАРГА



Г.ЛХАГВАЖАВ